



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/297

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Ойн хортны тэмцлийн ажлыг үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар тэмцэх (Орхон, Бугат, Сайхан, Хутаг-Өндөр, Баян-Агт, Хангаль сум-15000 га)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 2 дугаар багц “Орхон, Сайхан сумдад 4000 га талбай”-н ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Сайхан ойн төлөө” ХХК-тай 252,000,000 (хоёр зуун тавин хоёр сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Сайхан ойн төлөө” ХХК-ийн захирал (Д.Эрдэнэбулган)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажлын 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010409

Аймгийн Засаг даргын 20.15 оны
05 дугаар сарын 07-ны/ний өдрийн
A/297 дугаар захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	С.Цэдэнлхам
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	С.Цэдэнлхам